# Хадландчад зөвлөлгөө

Тэгш уудам өвс ихтэй талбайн өвсийг морин ба тракторын хадуураар хаддаг.

Хос морины К—1,4 маркийн хадуур машин өдөрт 4 га талбайн өвс хаддаг.

Авцын өргөн тракторынхоос нарийн учир эвдрэл гарах нь бага.

Морин хадуурыг хөнгөн шуурхай ажиллуулахын тул дор дурьдсан шаардлага биелүүлэх хэрэгтэй.

Сэжлүүр (шатуун)—ыг явах дугуйны тэнхлэгтэй зэрэгцээ чигтэй байлгахын т у л сэжлүүрийн урьд байдаг татуургыг урт богино болгож тохируулна.

Хэрэв сэжлүүр шулуун тавигдаагүй бол ангид хүйстэд (эксцентрикт) холбосон хуудас төмөр гулзгай байдалтай үзэгдэнэ.

Үүнийг тохируулахгүй бол моринд хүнд бөгөөд сэжлүүр амархан эвдэрнэ.

Хадах ангийн гадна талын хэрээ хушууны үзүүр явах тэнхлэгээс 26—35 мм урагшаа байх ёстой.

Хэрэв энэ хэмжээнд хүрээгүй бол хадах ангийн 6 нүхтэй ангид хүйстийг хөдөлгөж тохируулаад тэдгээрийн аль тохирсон нүхэнд нь боолт хийж бэхлэнэ.

Сэжлүүр нэг талдаа гарсан байхад хутганы сегмент, хэрээ хушуу хоёрын тэнхлэг бие биедээ давхцаж таарах ёстой.

Үүнийг голдуу сэжлүүрийн хэмжээгээр тохируулна. Хэрээ хушууны тагнайнууд нэг шулуун шугамд тохирсон байх ёстой.

Сегмент тагнай хоёрын хооронд 0,3—1 мм зайтай байхаар мэлхий даруулгаар тохируулна.

Хутга тагнай хоёрын хоорондын зай тохироогүй хадуурын ир мохоо бол өвс огтлох нь муу, ажиллахад моринд хүндрэх, сэжлүүр хугарах, хутганы нуруу төмөр тасрах, хэрээ хушуу эвдрэх нөлөөтэйг сануулштай.

Хадах ангийн гадна дотно талын шаахайн дотор байдаг ул төмрийг дээш доош нь болгож хадах өндрийг тохируулна.

Бартаа багатай талбайд 5 см—ээс дээгүүр хадаж болохгүй.

Морь хөллөсөн байхад модон арлын урьд үзүүр газраас дээш 90 см байх хэрэгтэй.

Ерөөс арал нь монгол моринд уртаддаг учир үзүүр талаас нь тайрч морь холбох модыг хойш нь болгож бэхлэх хэрэгтэй. Хадуур машиныг гүйцэд хурд аваагүй байхад хадалтад орвол сэжлүүр амархан эвдэрдэг.

Дээр дурьдсан зүйлийг анхаарч ажиллавал хөдөлмөрийн бүтээл сайтай, биед амар, зүтгэх хүчнээ ядрахаас хамгаална.

Сүүлийн үед тракторын КНУ—6 гэдэг зургаан метр өргөн авцтай хадуурыг өргөн хэрэглэдэг боллоо.

Энэ машины өдрийн норм 22 га, урагш давших хөдөлгөөнөөр цагт 5,61 км хурдтай ажиллаж тэгш сайн талбайд 5-6 см өндөр хадна.

Хадах ангийн тохируулга нь морин машинтай бараг ижил.

Чийг ихтэй өвсийг хадахад эврээсний дараа тракторын хөндлөн тармуураар тармана.

Намар өвс гандах үед КНУ—6 хадуур угсарсан тракторын араас хөндлөн тармуур зүүж ажиллана.

Ингэснээр тармуур чирэх тракторыг б у с а д ажилд хэрэглэх боломж олгоно.

# Амалснаа ажил болгодог хүн

МАХН-ын гишүүн Ядам Өнжүүл сумын 3 дугаар бригадад намын хэсгийн ахлагчаар үр бүтээлтэй ажиллаж байгаад энэ оны 2 дугаар сард өөрийн сумын тэргүүний малчин аймгийн 1967 оны хөдөө аж ахуйн барилгын аврага Балганы туршлагаар, гэр бүлээрээ хашаа барьж худаг гаргах санал гаргасан юм.

Ядамын энэ санаачлагыг намын үүрээс сайшаан дэмжиж ажлаас нь өөрчлөн амласан ажилд нь оруулсан юм.

Ядам «Элсэн цагаан толгой» гэдэг газар гэрээрээ бууж 2 дугаар сараас эхлэн худаг ухах ажилдаа орж 5,5 метр худаг 1 сарын дотор ухаж бүрэн ашиглалтанд оруулаад 4 дүгээр сараас хашаа барих ажилдаа орж уртаараа 24 метр, өргөнөөрөө 8 метр 700 хонины багтаамжтай саравчтай хашааг Балганы туршлагаар фундамент ухан шавардан барьж жорлон муу усны нүх зэрэг зүйлийг байнгын чанартай сайн хийж амласнаа ажил болголоо.

Одоо Ядам 500 тарвага агнах гэрээ хийж ангийнхаа ажилд гараад байна.

**Өнжүүл сумын намын үүрийн нарийн бичгийн дарга Дамдинсүрэн**

# ХАДГАЛАМЖИЙН ШИНЭ ХЭЛБЭР

Манай орны хөдөлмөрчид ах дүү социалист орны ард түмний туршлагаар хүүхдийн нэр дээр хадгаламж нээж хадгалуулах явдал өргөн дэлгэр болж байна.

Хүүхдийн төрсөн ойн өдөр, цэцэрлэг, ясли, сургуульд орсон анхны өдөр, эвлэлийн гишүүнд элсэх, их сургуульд орох, хүүхдийн баярын өдөр зэрэг тэмдэглэлт үйл явдал бүхий өдрүүдэд хадгаламжинд нь мөнгө хуримтлуулах хэлбэрийг манай хөдөлмөрчид өргөн хэрэглэж байгаа нь сайшаалтай юм.

Хүүхдийн нэр дээр сар бүр 25 төгрөг, 18 нас хүртэл хуримтлуулахад мөнгөний шагнал үржсээр 6000 гаруй төгрөгтэй болсон байна.

Манай эцэг эхчүүд үр хүүхдийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө ямагт санаа тавьж ирээдүйн нь материаллаг баазыг одоогоос эхлэн бэлтгэх нь зүйтэй.

Хадгаламжийн мөнгө нь хүүхэд насанд хүрч эрдэм сурах хөдөлмөрлөхөд амьдралын материаллаг бааз болдогийг орон нутгийн нам захиргааны байгууллагууд хөдөлмөрчдөд өргөн сурталчлах хэрэгтэй.

Энэ хэлбэрийг нийтээр ашиглаж хүүхэд бүрээ хадгаламжтай болгоцгооё.

**Ц.Далхаа**

# *Их хайрханы уулын үйлдвэрийн нийгмийн даатгалын зөвлөлийн ажлын туршлага*

Тус үйлдвэрийн дэргэдэх Шомбоо даргатай нийгмийн даатгалын зөвлөл, ажилчин албан хаагчдад үзүүлэх эмнэлгийн үйлчилгээ, эрүүлжүүлэх арга хэмжээний тухай нэгдсэн төлөвлөгөө зохион түүний биелэлтэнд хяналт тавихдаа хийгдэх зүйлүүдийг ажлын төлөвлөгөөнд тусган мөрдлөг болгож байна.

Эрүүл ахуй эмнэлэг гэгээрлийн суртал нэвтрүүлгийг эмнэлгийн байгууллагатай хамтран зохион явуулдаг бөгөөд э н э ажилд туслалцуулах зорилгоор нийгмийн даатгалын зөвлөлөөс тэтгэвэр авч байгаа өндөр настны болон тахир дутуугийн групптэй 23 хүний бүрэлдэхүүнтэй хэсэг байгуулан нийгмийн даатгалын зөвлөлийн дэргэд ажиллуулж байна.

Мөн ажилчин албан хаагчдын гэр бүлийн хүмүүсээс олон цөөн хоног о о р өвчилж амьдрал ахуйн хувьд хүндрэх байдал тохиолдвол өвчлөгсөд болон тэдний гэр бүлийн хүмүүсийг эргэх, мөнгөн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулж ажилладаг аж.

Нийгмийн даатгалын зөвлөлийн гишүүдээс эмнэлгийн байгууллагатай хамтран үйлдвэрийн хүнд хортой нөхцөлд ажиллагсдыг эмнэлгийн хяналтанд авахуулах, а ж и л ч д ы н эрүүл мэндийн үзлэгүүдийг хийлгэх, рашаан сувилал, амралтанд явуулах ажлыг эрхлэн х и й ж байна.

Хөдөлмөрийн чадвараа алдан группэд орсон хүмүүсийн тэтгэвэр авах материалуудыг зааврын дагуу бүрдүүлэхэд нь туслах, хорогдуулсан буюу хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдсөн ажил хийх акттай хүмүүсүүдэд үйлдвэрийн захиргаатай харилцан зохих тэнцэх ажлуудыг олгуулах, нэгдсэн журмаар уулзаж эрэлт хүсэлтий нь хүлээн авах ажил зохиодог байна.

Үйлдвэрийн хэмжээгээр ажилчин албан хаагчдын амралтын хуваарийг гаргуулан батлуулж, уг хавсралтын дагуу амруулах ажлыг зохион байгуулж байна.

Эмнэлгийн хуудас бичих, өлгий сүүний мөнгө авах зэрэг нийгмийн даатгалаас олгох, тэтгэмжийн асуудлыг нэгдсэн журмаар тогтоосон өдөр эмнэлэг, боловсон хүчин, санхүү, нийгмийн даатгалын зөвлөлийн гишүүд байлцан тогтмол бичдэг болсон нь ажилчин албан хаагчдын чирэгдлийг багасгаж, энэ ажил хөнгөн шуурхай явагддаг болсон байна.

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН ЦЭЕН-ОЙДОВ

Баянцогтын САА—н ҮЭ—ийн хорооны нийгмийн даатгалын зөвлөлийн гишүүн Цэен-ойдов нийгмийн даатгалын зөвлөлийн гишүүнээр 2 дахь жилдээ ажиллаж байна.

Гишүүн Цэен—ойдов нийгмийн даатгалын талаар ажилчин албан хаагчдад сурталчлах ажлыг байнга зохиодог.

Ялангуяа 1968 онд хөдөлмөр сонинд бичигдсэн лавлах ширээ, ҮЭ—ийн байгууллага, нийгмийн даатгалтай холбогдсон асуулт хариултын талаар бичигдсэн зүйлийн цуглуулга хийж энэ онд н и й т ажилчин албан хаагчдад 6 удаа я р и а хийж, давхарласан тоогоор бүгд 800 гаруй хүнд сурталчлах ажил зохиожээ.

Мөн ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулж эмчлүүлэх, рашаан сувилалд амруулах талаар захиргаатай хамтран хуваарь гаргаж уг хуваарийнхаа дагуу амруулж байна.

Бас ажилчдын хөдөлмөрийн дэвтрийг бүрдүүлэх талаар тусгай төлөвлөгөө гарган ажилласны үр дүнд, одоо т у с сангийн аж ахуйн нийт ажилчид хөдөлмөрийн бүрэн зөв хөтлөгдсөн дэвтэртэй болжээ.

**П.Сүхээ**

# *Эд хариуцагч*

Баянчандманий засварын газарт бүтээгдэхүүн ба тос шатахууны няраваар эмэгтэй Думаа ажилладаг.

Думаа үйлдвэрийн тоног төхөөрөмж бэлэн бүтээгдэхүүн тос шатахуун зэрэг олон мянган төгрөгний хөрөнгө хариуцаж байдаг юм.

Тэрээр захиалагч байгууллага ба үйлдвэрийн хэрэгцээнд бүтээгдэхүүн ба материалыг олгох ба хүлээж авахдаа баримтын бүрдэлийг гүйцэд хийлгэж хөнгөн шуурхай үйлчилдэгээс гадна үйлдвэрээс гарч байгаа бүтээгдэхүүнийг хүлээн авахдаа тоо ширхэг, чанарыг сайн шалгаж авдаг.

Мөн бүх хөрөнгийг нэр төрөл тоо ширхэгээр складын бүртгэл нээж өдөр дутмын гүйлгээг цэвэр нямбай хөтлөж орлого зарлагын баримтыг 7 хоног дутам санхүүд өгдөг нь баримтын эргэлтийг шуурхай болгож өр авлага барагдуулах дансны бичилтийг шуурхай болгоход сайн нөлөөг үзүүлж байна.

Агуулахын дотоод зүйлийг төрөлжүүлэн хаягтай болгож өдөр дутмын бүртгэлийг хөтлөсөн нь агуулахын үлдэгдлийг мэдэж үйлдвэрийн ажиллагаанд судалгааг хийхэд боломж олголцоо өгч байна.

**С.Бямбаа**

# *УРАЛДААН ДҮГНЭВ*

Заамар сум-нэгдлийн зөвлөл хадлан үйлдвэрлэлийн ажлыг эрчимжүүлэхэд зарласан социалист уралдааны болзлыг дүгнэв.

Үүнд Бадамдорж ахлагчтай техникийн 1 дүгээр бригад эхний 10 хоногийн төлөвлөгөөг 103 хувиар биелүүлж социалист уралдаанд 1 дүгээр байр эзлэж хадлангийн тэргүүний бригадад шилжин явах дарцаг авав. Төлөвлөгөөгөө 134 хувь биелүүлсэн хадагч Пүрэвжав, өвс тармах төлөвлөгөөгөө 160 хувь биелүүлсэн Г.Сандагсүрэн, өвс нуруулдах төлөвлөгөөгөө 124 хувь биелүүлсэн Гүндсамбуу, өвс ачих төлөвлөгөөг 112 хувь биелүүлсэн Б.Махбал, Наранхүү нарын зэрэг хүмүүс баярын бичиг үнэ бүхий зүйлээр шагнагдав.

**Ц.Даш**

Хариуцлагатай эрхлэгч Н.МӨНХӨӨ

(Х—00064) «Анхдугаар таван жил» сонины үйлдвэрт хэвлэв.

# Мал аж ахуйн суурь зохион байгуулалт

ХАА-н нэгдлүүдэд мал аж ахуйн суурь зохион байгуулалт жилээс жилд сайжирч суурийн ахлагч нарын хариуцлага, үүрэг роль өндөржсөөр байна.

Гэвч мал аж ахуйн суурь зохион байгуулалт зарим нэгдэлд хангалтгүй хийгдэж байна.

Мөн суурьт өвөлжөө, хаваржаа, худаг усыг эзэмшүүлэн өгөх ажил олигтой хийгдээгүйгээс өвөлжөө хаваржаа, хашаа саравч, худаг усыг засаж, сэлбэж эзэмших ажил эзэнгүйдэж үрэгдэх явдал ч гарч байна.

Суурьт нутаг бэлчээрийг зааж өгөөгүйгээс бэлчээрийг нөөцлөх, хувиартай ашиглах явдал хийгдэхгүй байна.

Зарим малчид сууриас хол зайдуу газар дур мэдэн нутаглаж удирдлага хяналтгүй дураар ажиллаж нийгмийн өмч хөрөнгөнд хохирол учруулах үзэгдэл ч байсаар байна.

Суурь малчдын хөдөлмөрийн ресурсийг нарийн судлаж тэдэнд зохих тооны мал хариуцуулан өгөх зэргээр өөртөө байгаа боломжоог зөв сайн ашиглах ажил муу хийгдэж байгаагаас нийгмийн хөдөлмөрт зарим хүмүүс хангалтгүй оролцож байна.

Суурийг бэхжүүлэх талаар нэгдлийн зөвлөлүүд бригад сууриудад тодорхой удирдамж, шийдвэр өгөх, эргэж шалгах ажлыг муу хийж байна.

Зарим бригад хэсгүүд нэгдлийн зөвлөлийн шийдвэргүйгээр суурьт өөрчлөлт хийх, малчдыг халж солих явдал байсаар байна.

Ийм байдлаас сүүрьт өгөгдсөн үйлдвэрлэлийн даалгавар түүний биелэлтийг шалгаж дүгнэх, дуудлага хариуцуулах эзэнгүй болох, хяналт шалгалт тавих явдалд бэрхшээл учруулж байна.

Суурийг нэгдэл бригадын зөвлөлөөс өдөр дутмын тодорхой удирдлагаар хангах, биечлэн туслах ажил хангалтгүй хийгдэж зөвхөн ерөнхий шаардлага хаяа нэг тавих төдийгөөр ажлаа хязгаарлаж байна.

Ийм ноцтой дутагдал ХАА—н нэгдлийн суурь зохион байгуулалтын ажилд байсаар байна.

Энэ бол ХАА—н нэгдлийн хөдөлмөр зохион байгуулалт, хөлсний системийг сайжруулах арга хэмжээний тухай гаргасан МАХН—ын Төв Хороо, БНМАУ—ын Сайд нарын Зөвлөлийн 1963 оны 210/330 дугаар тогтоолын заалтыг хангалтгүй биелүүлж байгаа баримт юм.

Мал аж ахуйн суурийг цаашид бэхжүүлэхэд хөдөлмөр зохион байгуулалтыг нарийн хийж малчдад зохих тооны мал хариуцуулан өвөлжөө хаваржаа хашаа саравч, худаг ус, нутаг бэлчээрийг эзэмшүүлэн өгөх ажлыг улам тодорхой хийх хэрэгтэй байна.

Суурийн малчдыг айлсуулах ажлыг хийх тийм нөхцөл боломжоо хаа ч бүрэн байна.

Суурийн малчдыг айл суулж хамтарч ажиллах явдлыг хөгжүүлэх нь олон талын ач холбогдолтой бөгөөд хамтын хөдөлмөрийн үндсэн хэлбэр юм.

Айлсаж хамтарч ажиллах нь юуны өмнө нийгмийн аж ахуйд тавих удирдлага, олон түмний хяналтыг ойртуулан төвлөрүүлэх, суурь малчдын дотор зохиох соёл хүмүүжлийн ажлыг чанаржуулах, мал ажиллагаанд боловсон арга ажиллагаа нэвтрүүлж малын арчилгаа маллагааг сайжруулах бэлчээр нутгийг хуваарьтай зөв сайн ашиглах зэрэг боломжуудыг бүрдүүлж өгөх юм.

Суурийн малчид нь мал маллах, хужир, шүү татах,хадлан тэжээл бэлтгэх, хашаа хороо барих, худаг ус гаргах, засварлах, байгалийн бэрхшээлтэй тэмцэх гэх мэт ажлыг бие биеийнхээ хүч туслалцаатайгаар хамтарч хийдэг хамтач ажиллагааг суурь бүрт өргөн нэвтрүүлэх явдал суурийг бэхжүүлэх үндэс мөн.

Мөн суурийг бэхжүүлэхэд суурийн ахлагчид, малчдын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх талаар тодорхой ажил зохиож тэдний ажлыг улирал, сараар мэдүүлж байх, малын арчилгаа маллагаа, ашиг шим ашиглалтын талаар үүрэг амлалт авахуулах, үйлдвэрлэлийн даалгавраар өгөгдсөн үүргийг малчид бүрт гардуулан өгч түүний гүйцэтгэлийг тогтмол дүгнэдэг байх ёстой.

Мөн суурийн малчдад үйлдвэрийн даалгаврыг биелүүлэх, давуулан биелүүлсэн нөхцөлд ноогдох үндсэн ба нэмэгдэл хөлсийг нэг адил сайн ойлгуулж байх нь суурийг удирдах бэхжүүлэх гол хэлбэр мөн.

Мөн суурьт хамаарагдах нийгмийн ба амины малын бүтэц, тоо толгой, хүн хүчний байдал, хөдөлмөрийн нөөц, тэдний дадлага,туршлагын талаар нэг адил судлах нь чухал юм.

**С.Пунцагдорж**

# Хадлангийн явцаас

Баянцогтын САА энэ онд 3550 тонн өвс бэлтгэн авахаар 7 дугаар сарын 24—нд механикжсан бригад 1, техникжсэн бригад 2-тойгоор хадланд гарч 8 дугаар сарын 13-ны байдлаар 1248 тонн өвс бэлтгэн аваад түүнээ боож малын өвөлжөө хаваржаанд татаж байна.

Тус САА-н захиргаа, ҮЭ—ийн нэгдсэн хорооноос хадланчдын дунд социалист уралдаан зарлан ажиллуулснаар тэдний идэвх өрнөж байна.

Саяхан уралдааны болзолыг дүгнэхэд Бат-Очир даргатай 3 дугаар бригад түрүүлж САА—н захиргаа, ҮЭ—ийн нэгдсэн хорооны шилжин явах туг авав.

**Ж.Төмөрсүх**



Тус аймгийн Баянцагаан, Сэргэлэн сумдын нутгийн зааг «Цахилдагийн хоолой» хэмээх газар ургамал ногоо тэгш зэлүүд сайхан бэлчээр билээ.

Ах дүүгийн найрамдалт БНУАУ-ын худаг усны мэргэжилтнүүд «Цахилдагийн хоолойн» хөрсөн дор ойрхон байсан усны судалыг олж өрөмдөөд жилийн дөрвөн улиралд байнга ажиллагаатай, элбэг устай, ховоо, хүн хэрэглэхгүй өөрөө ундарч байдаг таатай сайхан худаг гаргасан юм.

**Зургийг Г. Жамъян**

# *Баянхушууны зуслангаар*

Биднийг алтан шар замаар хурдлан явахад замын хоёр хажуугаар үр тариа, хүнсний ногоо тарьсан том том талбайнууд ээрээлжлэн өнгөрнө.

Бид явсаар Баянхушууг тойроход жаргаж байгаа улаан нарны шижирлэх цацраганд битүү бургасаар бүрхэгдсэн Угтаалын голын хөвөөн дэх зуслангийн байр үзэсгэлэнтэйеэ харагдаж, хөгжилдөгч багачуудын шингэн дуу чихнээ сонсогдох нь чимэгтэй. Бид зорьсон газраа ирээд, нэгэн гэрт орвол «МУИС»-ийн ромбо энгэртээ гялалзуулсан залуу амар мэнд мэдээд сэнгэнсэн айргаар зочиллоо.

Зочлох зуур «Одоо манай зуслангийн 3 дугаар ээлжинд 5-8 дугаар ангийн сурагчид ирээд ажиллаж байна.

Манай хүүхдүүд цөмөөрөө л ногоо тарьж арчлана. Адуу маллаж,гүү, үнээ саана.

Ямар ч хүнээс дутуугүй бүтээлтэй ажилладаг юм. Хичээлдээ амжилттай суралцаж, олон нийтийн ажилд идэвхитэй оролцдог ёстой л арван хуруу тэгш хүүхдүүд дээ» гээд ярьж байгаа энэ бор залуу зуслангийн захирал Жадамба ажээ.

Бид зуслангийн байдал сурагчдын амьдрал ажилтай танилцаж явахдаа захирлаас;

—Зуслан маань хир тохижиж байна даа гэхэд:

—Эхний ээлж 6 дугаар сард гарахдаа 6 платактай гарч байсан 2 сарын өмнөхийг бодвол одоо сайхан болж байна.

Эрэгтэй, эмэгтэй 35-40 хүүхэд суух 2 тасалгаа, радио узелийн өрөө бүхий барилга барьсан.

Зуслан хоолны ба айраг эсгэх газар, агуулахаар хангагдаад байна.

Мөн 126 вольтын хүчтэй цахилгаан станцаар зуслангийн орчмыг гэрэлтүүлж, «САМ 10» радио станц тавьж тогтмол нэвтрүүлэг хийдэг.

Сурагчид зуслангийн орчмын зүйлийг зориуд хайрлан хамгаалдаг.

Байрнуудынхаа хооронд зам тавьж, гортик хийсэн.

Хүүхдүүд маань биеийн тамирын талбай, усан санг өөрсдийн идэвхи санаачлагаар байгуулсан нь ашигтай зүйл болсон юм даа гэж ярилаа.

Эрэгтэй сурагчдын байраар орж ном уншиж суусан хүүтэй уулзвал тэр хүү өөрийгөө 8 дугаар ангийн эвлэлийн үүрийн дарга Бямбаахүү гэж танилцуулаад:

—Манай зуслан дээр эвлэл, пионерийн байгууллага ээлж бүрт ажилладаг юм.

Өглөөний гимнастикийг тогтмол хийж спортын тоглолт тэмцээнүүдийг үе үе зохиодог.

Лекц, улс төрийн сонсголыг тогтмол хийдэг.

Зусланд гарсаар аялал 8 удаа, баяр ёслолыг тэмдэглэн өнгөрүүлж, үдэшлэг 21 удаа зохиосон» гэж яриад биднийг радио узелд дагуулан оров.

Хананд өлгөөтэй нэгэн самбар анхаарлы минь татлаа.

—Үүнийг та нар хийсэн юм уу?

—Тиймээ, манай зуслан дээр уран зохиол, биеийн тамир, залуу байгальч, хөгжим зэрэг дугуйлангууд ажилладаг.

Залуу байгальчдын дугуйлангийхан Баянхушуу орчимд ургадаг 30 гаруй ургамлыг цуглуулж,эмийн, хадлан бэлчээрийн, хогийн гэж 3 ангилан энэ самбарыг хийсэн юм.

Бас энд амьдардаг амьтадын цуглуулга хийж энэ буланг байгуулсан гээд тайлбарлаж өглөө.

Захирлын, хийсэн ажлын бүртгэлтэй танилцахад зусланчдын хийж бүтээсэн зүйл багагүй байгаа нь илэрхий.

Энэ жил зуслангийнхан 14 га талбайд байцаа, лууван тариад услалт, сийрэгжүүлэлт, 1, 2, 3 дугаар зэрлэг авах ажлыг сайн хийжээ.

Ногооны талбайд бүх ажлыг сурагчид өөрийн гараар хийдэг юм байна.

Тэдний тарьсан ургац САА-н ногооны бригадуудаас тэргүүлж явна.

Удахгүй зуслангийн сурагчдын тарьсан ногооноос сонгон хураалт хийх ажээ.

Эднийхэн цөм жигд бүтээлтэй ажилладаг байна.Сайн дотроос онц сайн гэж байдаг билээ.

Ногоо тарих, арчлах, зэрлэг авах ажилд 7 дугаар ангийн Х. Батсүрэн, Б.Бадамханд, Р. Цэвэлмаа, 8 дугаар ангийн Норовзвай, саальчин охид 9 дүгээр ангийн И. Цэрэнчимэд, Б.Цэрэндулам, Саранцэцэг нар нөхдөө манлайлжээ. Зуслангийхнийг сүү цагаан идээгээр хангах зорилгоор 25 гүү, 5 үнээ сааж өдөрт бүх гүүнээсээ 75 л саам саах нормыг 120 хувь, үнээнээс саах сүүг 100 хувь сааж боловсруулан сурагчдын хоол ундад хэрэглэж байна. Гүү, үнээн дээр ажилдаг сурагчид гүү барьж айраг эсгэх, үнээ саах, цагаан идээ боловсруулах бүх ажиллагааг бие даан хийж сурчээ.

9 дүгээр ангийн сурагч Цэрэндагва, Сосорбарам нар 25 эмнэг гүүг саалинд сургаж, унагыг номхруулсан нь зуслангаар төдийгүй САА-д ч их тустай зүйл болсоныг САА-нхан шагшин ярьцгааж байна.

Энэ бүтээлч хамт олон бол Жаргалантын САА-н 10 жилийн дунд сургуулийн хөдөлмөр зуслангийхан юм шүү.

**Х.Дорж**